



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.moh.gov.mn

2022.08.19 № 2/3730
танай _____-ны № _____-т

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН
ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН
ТӨВ, БҮСИЙН ОНОШИЛГОО,
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ, АГЕНТЛАГ,
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА,
ЗАХИРАЛ НАРТ

Чиглэл хүргүүлэх тухай

“Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар”-ын хүрээнд эрүүл мэндийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлж, байрны урьдчилгаа төлбөр төлөхөд дэмжлэг үзүүлж ажиллах хүрээнд дараах чиглэлээр анхаарч ажиллана уу:

1. Эрүүл мэндийн яам болон Худалдаа хөгжлийн банк хооронд 2021 оны 5 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан Хамтын ажиллагааны санамж бичгийн дагуу төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын ажилтан, албан хаагчдад банкны бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү хүртээмжтэй үзүүлэх, тухайлбал 6 хувийн хүүтэй ипотекийн зээлийн хүсэлтийг тэргүүн ээлжинд хүлээн авч, судалж шийдвэрлэх боломжтой болохыг өөрийн байгууллага, орон нутгийн ажилтан, албан хаагчдад мэдээлж, дэмжлэг үзүүлэх;
2. Байрны урьдчилгаа төлбөр олгохоор байгууллага, орон нутгийн хэмжээнд сонгон шалгаруулсан эмч, сувилагч, эрүүл мэндийн бусад ажилтны судалгааг хавсралтаар хүргүүлж буй маягтын дагуу гаргаж, тус яамны Бодлого төлөвлөлтийн газарт нэгтгэн ирүүлэх, өөрчлөлт гарсан тохиолдолд энэ талаар мэдэгдэх.

Хавсралт 3 хуудастай:

1. Эрүүл мэндийн яам болон Худалдаа хөгжлийн банк хоорондын Хамтын ажиллагааны санамж бичгийн хуулбар, 2 хуудастай;
2. Байрны урьдчилгаа төлбөр олгох эмч, сувилагч, эрүүл мэндийн бусад ажилтны судалгаа гаргах маягт, 1 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА *Ц.Эрдэмбилэг* Ц.ЭРДЭМБИЛЭГ



144225826



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ



БАТЛАВ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
С.ЭНХБОЛД

С. Энхболд

БАТЛАВ.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ БОЛОН ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ
ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ**

2021 оны 05 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү Хамтын ажиллагааны санамж бичиг (цаашид “Санамж бичиг” гэх) нэг талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 14210 хаягт орших “Эрүүл мэндийн яам”-ыг төлөөлж Эрүүл мэндийн сайд С.Энхболд (цаашид “ЭМЯ” гэх), нөгөө талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 14210 Энхтайваны өргөн чөлөө 19 хаягт орших Худалдаа, хөгжлийн банкныг төлөөлж Гүйцэтгэх захирал О.Орхон (цаашид “Банк” гэх, тус тусад нь “Тал”, хамтад нь “Талууд” гэх) харилцан тохиролцож, дараах чиглэлийн хүрээнд хамтран ажиллахаар санамж бичиг байгуулав.

Санамж бичгээр Худалдаа, хөгжлийн банк нийгмийн хариуцлагын хүрээнд эрүүл мэндийн салбарт ажиллаж буй нийт ажилтнуудад банкны бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд илүү хүртээмжтэй байдлаар хамруулах замаар тэдний нийгэм эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, Эрүүл мэндийн яам нь энэхүү санаачилгыг дэмжин эрүүл мэндийн салбарын ажилтнуудад мэдээлэл хүргүүлж, санхүүгийн үйлчилгээ авах боломжоор ханган хамтран ажиллана. Талууд энэхүү хамтын ажиллагааг цаашид урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх, талууд эрх ашгаа харилцан хүндэтгэх, нээлттэй ил тод харилцах зарчмыг баримтална.

Нэг. Хамтын ажиллагааны чиглэл

- 1.1. Банк нь эрүүл мэндийн салбарын ажилтнуудад банкны бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү хүртээмжтэйгээр үзүүлэх, тухайлбал төрөөс хэрэгжүүлж буй 6 хувийн хүүтэй ипотекийн зээлийн хүсэлтийг өөрийн бүх салбар тооцооны төвөөр тэргүүн ээлжид хүлээн авч судлах, шийдвэрлэх зэргээр ажиллана.
- 1.2. Эрүүл мэндийн яам нь Банкны үзүүлж байгаа үйлчилгээний талаар мэдээллийг эрүүл мэндийн салбарын ажилтнуудад мэдээлэл хүргүүлж, хамтын ажиллагааны хүрээнд боломжит дэмжлэгийг үзүүлж ажиллана
- 1.3. Энэхүү санамж бичгийн хүрээнд талууд 2 жилийн хугацаанд хамтран ажиллахаар тохирсон бөгөөд энэхүү санамж бичгийн хугацаа дуусгавар болгох үед талуудаас цуцлах, дуусгавар болгох санал ирүүлээгүй бол санамж бичгийг дахин 2 жилээр 1 удаа сунгагдсан гэж үзнэ.
- 1.4. Шаардлагатай бол талууд тодорхой асуудлаар уулзалт хэлэлцээр хийн зохион байгуулалт, хугацаа, бэлтгэл ажлын талаар харилцан мэдээлэл солилцож болно.
- 1.5. Үйл ажиллагаатай холбогдуулан гуравдагч этгээдээс ирсэн аливаа санал, гомдлыг эвийн журмаар хамтран шийдвэрлэхийг эрмэлзэнэ.


- 1.6. Санамж бичигт дурдсан үйл ажиллагааг хангаж ажиллахтай холбоотой бүхий л асуудлаар талууд хамтран ажиллахад анхаарна.

Хоёр. Бусад


- 2.1 Энэхүү санамж бичгийг Улаанбаатар хотноо 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдөр хоёр эх хувь үйлдэв.
- 2.2 Талууд хамтран ажиллах явцдаа олж мэдсэн аливаа мэдээ, баримт материалыг өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд ашиглахгүй, гуравдагч этгээдэд задруулахгүй ажиллахаар харилцан тохиролцсон болно.
- 2.3 Энэхүү Санамж бичиг нь гэрээний эрх зүйгээр зохицуулагддаг аливаа эрх, үүрэг үүсгэхгүй буюу заавал биелэгдэх шинжийг агуулаагүй болно.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ЭРДЭМБИЛЭГ



ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНКНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ОРЛОГЧ
Б.БАЯРМАА



**"ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ ДЭМЖИХ САР"-ЫН ХҮРЭЭНД БАЙРНЫ УРЬДЧИЛГАА ТӨЛБӨР ОЛГОХООР
СОНГОН ШАЛГАРУУЛСАН ЭМЧ, СУВИЛАГЧ, ЭРҮҮЛ МЭНДИЙН БУСАД АЖИЛТНЫ СУДАЛГАА**

Эрүүл мэндийн байгууллагын нэр:

№	Эцэг/эхийн нэр	Нэр	нас	хүйс	Регистрийн дугаар	Мэргэжил	Албан тушаал	Ажилласан нийт жил	Тухайн байгууллагад ажилласан жил	Сарын дундаж цалин	Цалингийн картаар үйлчлүүлдэг банкны нэр	Холбоо барих утасны дугаар

Судалгааг нэгтгэсэн:

албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих утасны дугаарыг заавал бичнэ үү.